



Гадаадын иргэн, харьяатын газар нь 2021 онд хууль тогтоомж, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган, жилийн эхэнд дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа удирдан зохион байгуулж нэгэн оныг үдлээ.

Юуны өмнө өнгөрч буй онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Гадаадын иргэн, харьяатын газраас төрийн үйлчилгээг үзүүлж эхэлсэн, үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалсан түүхт 20 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Төрийн дээд шагнал “Алтан гадас одон”-гоор шагнагдсаныг онцлоход таатай байна.

Түүнчлэн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээнд инновац, программ хангамжийн дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн, үйлчилгээний шат дамжлагыг багасгах чиглэлээр олон шинэлэг ажлыг эхлүүлж үр дүн, үр шим нь үйлчлүүлэгчдэд хүрсэн ололт амжилтаар дүүрэн жил байлаа.

Цаашид цахим үйлчилгээний тоо, төрлөө нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд хүнд суртал, чирэгдэлгүй, чанар хүртээмжтэй хүргэх нь бидний дараагийн зорилт юм.

Та бүхэнд айлчлан ирж буй шинэ ондоо дэвшүүлсэн зорилгоо бүрэн хэрэгжүүлж, ололт амжилтаа бататган, өрх гэр бүл бүрд эрүүл энх, аз жаргал, амжилт бүтээл тэгш дүүрэн байхыг хүсэн ерөөе.

Хүндэтгэсэн,

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН
ГАЗРЫН ДАРГА


A handwritten signature in black ink, consisting of several loops and a long horizontal stroke extending to the right.

НЭРГҮЙН УУГАНБАЯР



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, Улсын онцгой комисс, Нийслэлийн онцгой комиссын шийдвэрийг баримтлан



2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийг дуустал чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөн, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

2021 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Гадаадын иргэн, харьяатын газар нь төрийн үйлчилгээг үзүүлж эхэлсэн, үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалсан түүхт 20 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Төрийн дээд шагнал “Алтан гадас одон”-гоор шагнагдлаа.

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1. ВИЗ, ЗӨВШӨӨРЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

1.1.1. ГАДААДЫН ИРГЭНД ҮЗҮҮЛСЭН ВИЗ, ВИЗИЙН ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:



2021 онд гадаадын 10924 иргэнд визийн зөвшөөрөл олгож, үүнээс 8596 иргэний визийн зөвшөөрлийг Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газарт, хилийн боомтод виз олгох 2328 иргэний визийн зөвшөөрлийг хилийн боомт, бүсийн газруудад илгээлээ.

Түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх хүсэлт гаргасан төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг үндэслэн гадаадын 19 иргэнд визийн шилжүүлэг, 9 иргэнд гарах-орох цагаачийн мэдэгдэл, 3372 иргэнд зохих ангиллын Монгол Улсын виз олгосон. (График 1)

| Визийн зөвшөөрөл | | Виз | Оршин суух зөвшөөрөл | | | Түр ирэгч | |
|------------------|----------------|------|----------------------|---------|--------|-----------------|--------|
| Хилийн чанадад | Хилийн боомтод | | олголт | сунгалт | хасалт | хаягийн бүртгэл | хасалт |
| 8596 | 2328 | 3375 | 5938 | 17337 | 4164 | 2291 | 2444 |


1.1.2. ГАДААДЫН ИРГЭНИЙ БҮРТГЭЛ, ХЯНАЛТ:

Эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг үндэслэн гадаадын 5938 иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгож, гадаадын 17337 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунган, оршин суух зөвшөөрөлтэй 4164 гадаадын иргэний бүртгэлд хасалт хийсэн. Оршин

суугаа хэлбэр нь өөрчлөгдсөн 220 иргэнд оршин суух хэлбэр солих үйлчилгээ үзүүлсэн байна. (График 1)

Гадаадын иргэнийг уригч 250 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийн дагуу гадаадын 673 иргэнд виз, бүртгэлийн талаарх мэдээлэл бүхий тодорхойлолт олгож, Монгол Улсад түр ирэгчээр ирсэн гадаадын 2291 иргэнийг хаягийн бүртгэлд бүртгэж, нутаг буцсан, статус өөрчлөгдсөн гадаадын 2444 иргэний бүртгэлд хасалт хийлээ.

Мөн Монгол Улсад 90 хүртэл хоногийн визтэй ирсэн болон визгүй зорчдог түр ирэгч гадаадын иргэдээс тус улсад байх хугацааг сунгуулах хүсэлтийг хянан 1075 иргэний байх хугацааг 30 хүртэл хоногоор сунгасан. (График 1)



Энэ оны тоон үзүүлэлтийг 2020 оны үзүүлэлттэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 72,0 хувь, оршин суух зөвшөөрөл олголт 50,3 хувь, оршин суух зөвшөөрлийн сунгалт 71,6 хувиар тус тус өсөж, виз олголт 49,7 хувь, оршин суух зөвшөөрлийн хасалт 65,5 хувь, түр ирэгчийн тус улсад байх хугацааны сунгалт 65,6 хувиар тус тус буурчээ.

Цахим хэлбэртэй “Монгол Улсад оршин суух үнэмлэх” 10907 ширхэгийг шинээр хэвлэж, 12428 үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунган, 830 үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийлээ.

Оршин суух зөвшөөрөл авах болон оршин суух зөвшөөрлөө сунгуулах хүсэлт ирүүлсэн гадаадын 2081 иргэний хүсэлтийг шийдвэрлэж, гадаадын 25 иргэнд регистрийн дугаар, 1 иргэнд зорчих үнэмлэх олгов.

Тайлант хугацаанд нийт 1426 аж ахуйн нэгж, байгууллагын 2712 гадаадын иргэний хүсэлтийг цахим (eimmigration.mn)-аар хүлээн авч, холбогдох хууль, журмын дагуу хянан, шийдвэрлэсэн.



“Evisa.mn” цахим системээр нийт 21 улсын 83 иргэнд цахим виз олгож, 3 иргэний визийн хүсэлтэд татгалзсан.

Энэ оны тоон үзүүлэлтийг 2020 оны үзүүлэлттэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 72,0 хувь, оршин суух зөвшөөрөл олголт 50,3 хувь, оршин суух зөвшөөрлийн сунгалт 71,6 хувиар тус тус өсөж, виз олголт 49,7 хувь, оршин суух зөвшөөрлийн хасалт 65,5 хувь, түр ирэгчийн тус улсад байх хугацааны сунгалт 65,6 хувиар тус тус буурчээ.




Цахим хэлбэртэй “Монгол Улсад оршин суух үнэмлэх” 10907 ширхэгийг шинээр хэвлэж, 12428 үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунган, 830 үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийлээ.

Оршин суух зөвшөөрөл авах болон оршин суух зөвшөөрлөө сунгуулах хүсэлт ирүүлсэн гадаадын 2081 иргэний хүсэлтийг шийдвэрлэж, гадаадын 25 иргэнд регистрийн дугаар, 1 иргэнд зорчих үнэмлэх олгов.

Тайлант хугацаанд нийт 1426 аж ахуйн нэгж, байгууллагын 2712 гадаадын иргэний хүсэлтийг цахим (eimmigration.mn)-аар хүлээн авч, холбогдох хууль, журмын дагуу хянан, шийдвэрлэсэн.

“Evisa.mn” цахим системээр нийт 21 улсын 83 иргэнд цахим виз олгож, 3 иргэний визийн хүсэлтэд татгалзсан.



1.2. ИРГЭНИЙ ХАРЬАЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

1.2.1. МОНГОЛ УЛСЫН ХАРЬААТ БОЛОХ:

2010 оноос хойш Монгол Улсын харьяат болсон, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон, харьяатаас гарсан казах иргэдийн талаарх танилцуулгыг 11 дүгээр сарын 9-ний өдөр Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 140, 152, 162, 163, 175, 176, 177, 178, 190, 191, 206 дугаар зарлигаар 4 улсын 7 иргэн (Бүгд Найрамдах Казахстан Улсын 1, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 4, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын 1, Оросын Холбооны Улсын 1), харьяалалгүй 4 хүн тус тус Монгол Улсын харьяат болсон. (График 2)

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан 4 улсын 23 иргэн (Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 20, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын 1, Оросын Холбооны Улсын 1, Румын Улсын 1), харьяалалгүй 2 хүн, нийт 25 хүсэлт, баримт бичгийг шинээр хүлээн авч, Харьяатын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-т заасан шалгуурыг хангаагүй 2 улсын 6 иргэн (Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 5, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын 1), харьяалалгүй 3 хүний хүсэлтийг түдгэлзүүллээ.

1.2.2. МОНГОЛ УЛСЫН ХАРЬААТААС ГАРАХ:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 148, 150, 2021 оны 02, 18, 83, 84, 85, 86, 87, 88, 89, 98, 179, 180 дугаар зарлигаар 212 иргэн тус тус Монгол Улсын харьяатаас гарч бусад улсын харьяат болсон. (График 2)

- Бүгд Найрамдах Австри Улсын 19;
- Бүгд Найрамдах Солонгос Улсын 70;
- Бүгд Найрамдах Хятад Ард Улсын /Тайвань/ 1;
- Бүгд Найрамдах Казахстан Улсын 21;
- Бүгд Найрамдах Сингапур Улсын 5
- Нидерландын Хаант Улсын 3;
- Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын 71;
- Япон Улсын 22.

Монгол Улсын харьяатаас гарч бусад улсын харьяат болох хүсэлт гаргасан нийт 163 иргэн (Америкийн Нэгдсэн Улсын 1, Бүгд Найрамдах Австри Улсын 13, Бүгд Найрамдах Казахстан Улсын 22, Бүгд Найрамдах Солонгос Улсын 46, Бүгд Найрамдах Сингапур Улсын 1, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын 1, Нидерландын Хаант Улсын 1, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын 62, Япон Улсын 16)-ний хүсэлт, баримт бичгийг шинээр хүлээн авав.

1.2.3. МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХАРЬААЛЛАА СЭРГЭЭН ТОГТООЛГОХ:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 96, 97, 192 дугаар зарлигаар 21 харьяалалгүй хүн Монгол Улсын иргэний харьяаллаа тус тус сэргээн тогтоолгосон. (График 2)

Бүгд Найрамдах Казахстан Улсын харьяатаас гарч Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан 14 иргэний хүсэлт, баримт бичгийг шинээр хүлээн авлаа. 2021 оны жилийн эцсийн байдлаар тус байгууллагаар үйлчлүүлсэн иргэдээс хоёрдмол харьяалал үүсгэсэн 52 улсын 3965 иргэний мэдээлэл гадаадын иргэний нэгдсэн мэдээллийн санд бүртгэлтэй байна. Тайлант хугацаанд 164 иргэнийг шинээр бүртгэжээ.



1.2.4. ОЛОН УЛСЫН БОЛОН ГАДААД УЛСЫН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН БҮРТГЭЛ, ХЯНАЛТ:

Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаатай холбоотой нийт 56 байгууллагын хүсэлт (шинээр үйл ажиллагаа эрхлэх 3, зөвшөөрлийг хүчингүй болгох 2, зөвшөөрлийн хугацааг сунгуулах 51)-ийг шинээр хүлээн авсан.

Байгууллагын “Мэргэжлийн зөвлөл”-ийн 4 удаагийн хуралдаанаар хүсэлт ирүүлсэн нийт 61 олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын хүсэлт (шинээр үйл ажиллагаа эрхлэх 3, зөвшөөрлийг хүчингүй болгох 9, зөвшөөрлийн хугацааг сунгуулах 49)-ийг хэлэлцүүлж, шийдвэрлэв. Мөн 41 төрийн бус байгууллагын 2020 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланг хүлээн авлаа.

1.2.5. ХҮҮХЭД ҮРЧЛЭЛТ:

Байгууллагын даргын 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/181 дүгээр тушаалаар Монгол Улсын харьяат 1 хүүхдийг Америкийн Нэгдсэн Улсын иргэн, гэр бүлд үрчлүүлэхээр шийдвэрлэж, 3 дугаар сарын 16-ны өдөр үрчлэлтийн дараа хяналт тавих 2 талт гэрээг байгуулсан.

Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах хүсэлт гаргасан 2 улсын 2 гэр бүл (Бүгд Найрамдах Солонгос Улсын 1, Бүгд Найрамдах Итали Улсын 1)-ийн хүсэлт, баримт бичгийг шинээр хүлээн авлаа.

Гадаадын иргэн, гэр бүл (Америкийн Нэгдсэн Улсын 7, Бүгд Найрамдах Итали Улсын 6, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын 2, Холбооны Бүгд Найрамдах Герман





Улсын 21, Бүгд Найрамдах Франц Улсын 26)-д үрчлэгдсэн нийт 62 хүүхдийн тайланг хүлээн авч, мэдээллийн санд бүртгэсэн.

2020 онд үрчлэлтийн дараах тайлан ирүүлээгүй 59 хүүхдийн жагсаалтыг Гадаад харилцааны яамны Консулын газарт хүргүүллээ.

2021 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсаас гадаадын иргэн, гэр бүлд 273 хүүхэд үрчлэгдээд байна.

1.3. ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

1.3.1. ГАДААДЫН ИРГЭНД ТАВИХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ:

Байгууллагын даргын 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/185 дугаар тушаалаар “Гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн ажиллах заавар”-ыг шинэчлэн баталлаа.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлттэй холбогдуулан “Гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлэх, гарахыг түдгэлзүүлэхийг хүчингүй болгох тухай шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж, байгууллагын даргын 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/184 дүгээр тушаалаар баталсан.



Бүртгэлээр тавих хяналт шалгалтын хүрээнд байгууллагын даргын 09 дүгээр сарын 22-ны өдрийн “Гадаадын иргэний виз, бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд түүвэрлэлт хийх тухай” 01/06-12 дугаар удирдамжаар төвийн 2, орон нутаг дахь 7 нэгжид 215 улсын 151170 гадаадын иргэний хугацаа хэтрүүлсэн мэдээллийг шалгахад Монгол Улсын хилээр гарсан 107727, хилээр гараагүй 41542, оршин суух зөвшөөрөлтэй 1728, нас барсан 173 иргэн байсан талаар холбогдох мэдээллийг Хил хамгаалах ерөнхий газарт шилжүүлэхээр шийдвэрлэлээ.

Тайлант хугацаанд 35 удаагийн төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 196 аж ахуйн нэгж, байгууллагын 1315 гадаадын иргэнийг хамруулан, паспорт, түүнийг орлох баримт бичгийг шалгаж, Зөрчлийн тухай хуулийн дагуу гадаадын 1 иргэнд торгох шийтгэл оногдуулж, 4 аж ахуйн нэгжид албан шаардлага хүргэсэн.

Төлөвлөгөөт бус 199 удаагийн хяналт шалгалтаар 240 аж ахуйн нэгж, байгууллага, 701 гадаадын иргэний паспорт, түүнийг орлох баримт бичгийг шалгаж, иргэний харьяаллын талаарх 8 зөрчил, виз, оршин суух зөвшөөрлийн хугацаа хэтрүүлсэн 13 зөрчлийг илрүүлэн, Зөрчлийн тухай хуулийн дагуу гадаадын 5 иргэнд торгох шийтгэл оногдуулж, 4 иргэнийг Монгол Улсаас албадан гаргаж, 9 иргэнийг торгох шийтгэлээс чөлөөлж, 1 иргэний визийн зөвшөөрлийг хүчингүй болгон, 1 аж ахуйн нэгж, байгууллагад албан шаардлага хүргүүллээ.

Тайлант хугацаанд нийт 29 улсын 111 гадаадын иргэн, 8 уригч байгууллага (12 иргэн)-д Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн дагуу нийт 37,280,000 төгрөг (Гучин долоон сая хоёр зуун наян мянган)-ийн торгох шийтгэл оногдууллаа. (График 3)



Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2, 37.1.4, 37.1.7, 37.1.11, 37.1.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн 14 улсын 31 иргэнийг байгууллагын даргын 29 удаагийн тушаалаар Монгол Улсаас албадан гаргасан. (График 3)



2021 оны тоон үзүүлэлтийг 2020 оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 75,9 хувь, зөрчил гаргасан уригч хуулийн этгээд 98,7 хувь, албадан гаргагдсан гадаадын иргэн 83,0 хувь, гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн 63,2 хувиар тус тус буурч, зөрчил гаргасан уригч иргэн бүртгэгдээгүй байна.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.7.4 дэх заалтыг үндэслэн албадан гаргасан 2 улсын 2 гадаадын иргэний Монгол Улсын хилээр нэвтрэх эрхийг хугацаанаас өмнө сэргээсэн.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 7 улсын 28 иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлж, 6 улсын 20 иргэнийг гарахыг түдгэлзүүлснийг хүчингүй болгож, хилээр нэвтрэх эрхийг сэргээсэн байна.

“Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам” (Уг журам Засгийн газрын 2021 оны 193 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдахаас өмнө)-ын 4.2-т заасныг үндэслэн 1 улсын 1 иргэний Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг сунгажээ.

ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ЧИГЛЭЛЭЭР:

1.1. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ТӨЛӨВЛӨГӨӨ, ТАЙЛАН:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2020 он, 2021 оны эхний хагас жилийн хэрэгжилт, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн байгууллагад холбогдох арга хэмжээний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 2021 оны 01/137 01/862 дугаар, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явцын тайланг 01/1496 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлэв.

Улсын Их Хурлын чуулган дээр Монгол Улсын Ерөнхий сайдын хэлсэн үгэнд тусгагдсан нэн тэргүүнд хэрэгжилтийг хангах шаардлагатай, Засгийн газрын 100 хоногт хэрэгжүүлсэн ажлын тайланд байгууллагад хамаарах зорилт, арга хэмжээний гүйцэтгэлийг 4 дүгээр сарын 26-ны өдрийн 01/613 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд, 01/614 дүгээр албан бичгээр Гадаад харилцааны яаманд, уг тайланд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг мөн сарын 28-ны өдрийн 01/617 дугаар албан бичгээр



Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийн 2021 оны хагас жилийн хэрэгжилт, Улсын Их Хурлын 2019 оны “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэрэгжүүлсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 62 дугаар тогтоолын хэрэгжилт, “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10,0 их наядын цогц төлөвлөгөө”-ний хагас жилийн хэрэгжилтийг 2021 оны 01/534, 01/95 01/11722 дугаар албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Коронавируст цар тахлын үед хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, цар тахлын нөлөөг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-ний 3 дугаар улирлын хэрэгжилтийг тус тус 10 дугаар сарын 5-ны өдрийн 03/1351 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.

Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2020 оны төлөвлөгөөний тайлан, байгууллагын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2021 оны хагас жилийн хэрэгжилтийг 02/05, 01/963 дугаар албан бичгээр Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд тус тус хүргүүлсэн.

Агаарын тээврийг хялбаршуулах үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилт, Агаарын тээврийг хялбаршуулах зөвлөлийн 2021 оны ээлжит хуралдаанд хэлэлцэх асуудалд саналыг 01/880, 01/1020 дугаар албан бичгээр Иргэний нисэхийн ерөнхий газарт, Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг 01/1015 дугаар албан бичгээр Иргэний нисэхийн үндэсний төвд, Агаарын тээврийг хялбаршуулах үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг 01/1639 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын дагуу 1, 2, 3 дугаар улирлын танилцуулах мэдээг 01/445, 01/926, 01/1303 дугаар албан бичгээр мөн Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн.

| Төрөл | 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө | 2021 оны үйл ажиллагааны гүйцэтгэл |
|---|-------------------------------------|------------------------------------|
| Хүний эрхийн хөтөлбөр | 6553 | 10504 |
| Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах | 6704 | 3372 |
| Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх | 48 | 5 |
| Хүн худалдаалахтай тэмцэх | 3002 | 5838 |
| Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх | 10106 | 17337 |
| Агаарын тээврийг хялбаршуулах | 12073 | 4164 |
| Хүн худалдаалахтай тэмцэх | 13 | 25 |
| Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах | 7 | 11 |
| Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх | 212 | 183 |
| Хүн худалдаалахтай тэмцэх | 245 | 212 |
| Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх | 15 | 14 |
| Агаарын тээврийг хялбаршуулах | 0 | 21 |
| Хүн худалдаалахтай тэмцэх | 1 | 1 |
| Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах | 1 | 3 |
| Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх | 4 | 0 |
| Хүн худалдаалахтай тэмцэх | 26 | 40 |

Байгууллагын үйл ажиллагааны 1 дүгээр сараас 11 дүгээр сарын тайланг боловсруулж, тоон мэдээг инфографик хэлбэрээр 11 удаа, байгууллагын 2021 оны хагас жилийн үйл ажиллагааны тайланг 6 дугаар сарын 25-ны өдрийн 01/927 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлж, байгууллагын цахим хуудаст байршуулан олон нийтэд нээлттэй мэдээлэв.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг, даалгаврын 1, 3 дугаар улирал, хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2021 оны 01/519, 01/958, 01/1353 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн яамны “2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-нд байгууллагаас тусгах санал болон байгууллагын танилцуулгыг 2 дугаар сарын 9-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагуудын “2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө” батлах тухай А/150 дугаар тушаалаар “Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-г батлав.

Засгийн газрын 2021 оны 218 дугаар тогтоолоор баталсан журам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 100 дугаар тушаалаар баталсан загварын дагуу байгууллагын

2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, 1 дүгээр сарын 22-ны өдрийн 01/92 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, Хууль зүй, дотоод хэргийн сайд 2 дугаар сарын 22-ны өдөр баталлаа.

Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолоор баталсан журам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47 дугаар тушаалаар баталсан загварын дагуу байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн тайланг 1 дүгээр сарын 4-ний өдрийн 01/02 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн байна.

2.1.2. АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ, ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТ:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн А/20 дугаар тушаалаар баталсан “Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц”-ээр батлагдсан 310 орон тоонд үндэслэн байгууллагын зохион байгуулалтын нэгжүүдэд бүтцийн өөрчлөлт хийлээ.

“Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг 5 бүлэг, 8 зүйлтэй, 4 үндсэн зорилтын хүрээнд 41 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөж, Даргын дэргэдэх зөвлөлийн 3 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, байгууллагын даргын 2021 оны А/62 дугаар тушаалаар баталсан.



Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор Гадаадын иргэн, харьяатын газрын төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах 2021 оны төлөвлөгөө, Гадаадын иргэн, харьяатын газрын сургалтын 2021 оны төлөвлөгөө, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны “Сургалтын бодлогыг хэрэгжүүлэх тухай” зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тус тус баталж, төлөвлөгөөний хэрэгжилт жилийн дүнгээр 95,8 хувийн биелэлттэй байна.


2021 онд хяналтын улсын байцаагчийн хилийн боомт, орон нутагт ажилласан хугацааны урамшуулалд хамрагдах эрх үүссэн 10 албан хаагчид байгууллагын даргын тушаалаар 252,035,089 төгрөгийг олголоо.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 132 дугаар захирамжаар 2 албан хаагчийн эрхэлсэн түшмэлийн зэрэг дэвийг ахиулан, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/251 дүгээр тушаалаар 20 албан хаагчид дэс түшмэлийн зэрэг дэвийг шинээр, 35 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан олгосон.



Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын дагуу нийт 52 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн улирлын үнэлгээгээр ур чадварын нэмэгдлийг давхардсан тоогоор 141 албан хаагчид тус тус олгосон байна.

2021 онд Төрийн албанд үр бүтээлтэй ажилласан нийт 80 албан хаагчид шагнал гардуулах ёслолын ажиллагааг зохион байгуулав. Үүнд: Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 2, Алтан гадас одонгоор 6, Хөдөлмөрийн хүндэт медалиар 6, Хууль зүйн салбарын “Тэргүүний ажилтан хүндэт тэмдэг”-ээр 12, Хууль зүй, дотоод хэргийн яамны “Хүндэт жуух бичиг”-ээр 37, Сангийн яамны “Жуух бичиг”-ээр 1, Гадаадын иргэн, харьяатын газрын “Жуух бичиг”-ээр 12, Төрийн бусад байгууллагын шагналаар 4 албан хаагч шагнагдсан.



Сахилга хариуцлагын ёс зүйн алдаа дутагдал гаргаж хангалтгүй ажилласан төрийн захиргааны албан хаагч 19, төрийн үйлчилгээний албан хаагч 3, нийт 22 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулж, хариуцлага тооцлоо. Үүнээс сануулах 13, цалинг 2 сарын хугацаанд 20 хувь хасах 1, цалинг 3 сарын хугацаанд 10 хувь хасах 4, цалинг 3 сарын хугацаанд 20 хувь хасах 1, ажлаас халах 3 байна.



2021 онд нийт 3 удаагийн сонгон шалгаруулалтаар удирдах албан тушаалын 2, гүйцэтгэх албан тушаалын 23 сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг зохион байгуулж, сонгон шалгаруулалтын тайланг Төрийн албаны зөвлөлийн Сонгон шалгаруулалтын газарт хүргүүлж ажилласан. Сул орон тоог нөхсөн иргэдийн 12 буюу 40,0 хувь нь төрийн албанаас түр чөлөөлөгдсөн иргэний нөөцөд бүртгэлтэй, 13 буюу 56,5 хувь нь 2020-2021 оны төрийн албаны ерөнхий шалгалтын нөөцөд бүртгэлтэй иргэд байлаа.

Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний болон Улс тунхагласны баярын өдрийг тус тус тохиолдуулан төрийн жинхэнэ албан хаагчийн 15, гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн 7, нийт 22 албан хаагчийн тангараг өргүүлэх ёслолын арга хэмжээг зохион байгуулав.


Гадаадын иргэн, харьяатын газраас авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 9 зорилтын хүрээнд 36 арга хэмжээг, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 10 зорилтын хүрээнд 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус боловсруулж, баталсан.

Тайлант хугацаанд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу 122 иргэний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хянуулж, байгууллага хооронд шилжин томилогдох 1, нэгж хооронд шилжин томилогдох 50, байгууллага болон нэгж хооронд сэлгэн ажиллах 2, албан тушаал дэвшин ажиллах 17, шинээр томилогдох 30, түр орлон гүйцэтгэгчээр ажиллах 5, албан тушаалын ангилал ахисан 2, жинхэлж томилогдсон 15, их

хэмжээний орлого мэдүүлсэн 17 албан хаагчийн мэдээллийг “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим систем”-д бүртгэлээ.

Сургалт нийгмийн баталгааны 2021 оны төлөвлөгөөний дагуу байгууллагаас шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх, хяналтын улсын байцаагчийн эрх олгох, шинэчлэн батлагдсан хууль тогтоомжийг танилцуулах, сургагч багш нарыг бэлтгэх, гадаад орнуудын хөгжлийн бодлого дипломат ёс, харилцаа ба хандлагыг судлах, жөндөрийн өнөөгийн нөхцөл байдлыг танилцуулах, төрийн албаны шинэчлэл, ёс зүйн хандлага, хувь хүний харилцаа ба багийн ажил, эрүүл мэндээ хамгаалах, хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг олгох, донтолт ба сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр нийт 26 удаагийн сургалтыг танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 1771 албан хаагч хамрагдлаа.

Мөн Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Удирдлагын академи, Дотоод хэргийн их сургууль, Америкийн Нэгдсэн Улсын ЭСЯ, Төрийн худалдан авалтын газар зэрэг төрийн болон бусад байгууллагатай хамтран “Алсын хараа 2050”, “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжийн онол, арга зүй”, “Англи хэлний анхан ба дунд шатны мэдлэг олгох”, “Нийтийн болон хувийн ашиг сонирхол, ашиг сонирхлын зөрчил”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтныг бэлтгэх”, “Нотлох баримт бэхжүүлэх нь”, “Баримт бичгийн нууцлал, хуурмаг баримт бичгийг таних нь”, “Төрийн болон албаны нууцын тухай хууль”, “Төрийн худалдан авалт” сэдвүүдээр зохион байгуулсан нийт 28 удаагийн сургалтад 140 албан хаагчийг хамруулсан байна.



Төрийн албаны тухай хууль, төрийн албан хаагчийн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн хүрээнд байгууллагын төрийн жинхэнэ албан хаагчийг мэргэшүүлэх зорилгоор 2021 онд мэргэшүүлэх 8 төрлийн сургалтад нийт 49 албан хаагчийг Удирдлагын академид суралцууллаа.

Монгол Улс дахь гадаад улсын элчин сайдын яамд, бусад орны адил чиг үүрэгтэй байгууллагуудтай хамтын ажиллагааны хүрээнд энэ онд Тайваний Боловсролын яамны хятад хэлний тэтгэлэгт хөтөлбөрт 4, Тажикстан улсын “Хилийн менежмент” сургалтад 1, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Нийгмийг аюулаас хамгаалах яамны харьяа Ардын цагдаагийн их сургуулийн “Монгол Улсын хилээр орох, гарах асуудлын удирдлагын сургалт-2021” цахим сургалтад 20 албан хаагчийг суралцуулсан.

2.1.3. ОЛОН НИЙТ, МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ:

Тайлант хугацаанд байгууллагын цахим хуудаст үйл ажиллагаатай холбоотой 109 мэдээ, мэдээллийг байршуулж, давхардсан тоогоор 441 хэвлэл мэдээллийн хэрэгсэл (телевизээр 66, сонинд 40, сайтад 335)-ээр сурталчилсан. MYOHT, UBS, TV5, NTV телевиз, өдөр тутмын Өнөөдөр сонин, Өглөөний сонин, Үндэсний шуудан сонин, Монголын Үнэн сонин, Montsame агентлаг, Gogo мэдээний агентлаг, ikon.mn, news.mn, mnb.mn, zindaa.mn сайт зэрэг 20 орчим хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцан ойлголцлын хүрээнд хамтран ажиллаж байна.



Байгууллагын дарга Н.Ууганбаяр 2 дугаар сарын 13-ны өдөр “Засаг цаг” хөтөлбөрт, 3 дугаар сарын 10-ны өдөр УИХ-ын Тамгын газраас бэлтгэдэг “УИХ-ын цаг” нэвтрүүлэгт, 5 дугаар сарын 5-ны өдөр Bloomberg телевизийн “Ярилцах цаг” нэвтрүүлэгт, 5 дугаар сарын 19-ний өдөр UBS телевизийн “Нүүр тулсан ярилцлага” нэвтрүүлэгт, 6 дугаар сарын 8-ны өдөр англи хэлээр мэдээ, мэдээллээ бэлтгэн хүргэдэг C Channel Mongolia телевизийн “Онцлох ярилцлага” нэвтрүүлэгт тус тус оролцож, байгууллагын үндсэн үйл ажиллагаа болон Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт, цахим үйлчилгээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл хүргэлээ.



Байгууллагын дарга 3 дугаар сарын 19-ний өдөр хэвлэлийн хуралд оролцож, ТВ9, Ийгл, UBS, ETV телевиз, ikon.mn, news.mn, zindaa.mn, zarig.mn, 24 tsag.mn зэрэг мэдээллийн сувгуудаар дамжуулан гадаадын иргэнд тавих хяналт шалгалттай холбоотой асуудлаар олон нийтэд мэдээлэл хүргэсэн.

Түүнчлэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, шинэ зохицуулалтын талаар 5 дугаар сарын 17-ны өдөр ТВ8 телевизийн “Толь” мэдээллийн хөтөлбөр, 5 дугаар сарын 21-ний өдөр МҮОНТ-ийн “Цагийн хүрд” хөтөлбөр, 6 дугаар сарын 4-ний өдөр ТВ9 телевизийн “Энэ өдөр” мэдээллийн хөтөлбөрт тус тус ярилцлага, мэдээлэл өгч ажиллалаа. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар танилцуулах уулзалт, зөвлөгөөнийг гадаад улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Дипломат төлөөлөгчийн газруудтай хамтран зохион байгуулж, 5 дугаар сарын 24-ний өдөр Бүгд Найрамдах Солонгос Улсын ЭСЯ, 5 дугаар сарын 27-ны өдөр Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын ЭСЯ, 10 дугаар сарын 22-ны өдөр олон улс болон гадаад улсад төвтэй төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын төлөөлөлд тус тус зохион байгуулав. Арга хэмжээг UBS, TV8 телевиз, C Channel телевиз, zindaa.mn, montsame.mn, mnb.mn mnews.mn, ontslokh.mn сайтаар сурталчилж, олон нийтэд мэдээллээ.



10 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсад зохион байгуулагдсан “ITM 2021” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгийн арга хэмжээг Монгол HD, UBS, TV8 телевиз, zindaa.mn, mnb.mn сайтаар, 10 дугаар сарын 29-ний өдөр цахим визээр нэвтэрсэн анхны гадаадын иргэний угтан авч, мэдээллийг NTV телевиз, dnn.mn, assa.mn, mnb.mn, 24tsag.mn, zindaa.mn зэрэг 12 сайтаар тус тус олон нийтэд хүргэж ажилласан.

2.2. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ, ГАДААД ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

2.2.1. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ:



2021 онд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан дагаж гарах журмуудыг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, 2021 оны 192 дугаар тогтоолоор “Монгол Улсын виз олгох журам”, 193 дугаар тогтоолоор “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах, албадан гаргахгаас чөлөөлөх болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”, 194 дүгээр тогтоолоор “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам”, 195 дугаар тогтоолоор “Улсын тэмдэгтийн хураамж, визийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай”, 197 дугаар тогтоолоор “Монгол Улсын визийн төвийн байршлыг тогтоох, сонгон шалгаруулах, гэрээ байгуулан ажиллах журам”-ыг тус тус баталсан.

Энэ онд байгууллагын даргын 2021 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн “Хууль тогтоомжийн сургалт, сурталчилгааны ажлын зохион байгуулалтын тухай” А/96 дугаар тушаалаар сургалтын 4 багийн 9 сургагч багшийг бэлтгэж, 12 удаагийн сургалтаар төв болон орон нутгийн хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллага, хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, Аялал жуулчлалын холбоо зэрэг байгууллагын албан хаагч, мэргэжилтэн нийт 795 хүнд хуулийн нэмэлт, өөрчлөлтийг танилцуулах сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулав.

Агаарын замын боомт хариуцсан газрыг Чингис хаан олон улсын нисэх буудал руу шилжүүлэхтэй холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны “Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц батлах тухай” А/20 дугаар тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг хүргүүлж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/258 дугаар тушаалаар өөрчлөлт орууллаа.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан “Дотоод хяналт, шалгалт зохион байгуулах журам”, “Албан хаагчдын дүрэмт хувцас өмсөх, хэрэглэх журам”, “Хөдөлмөрийн дотоод журам”, “Шуурхай хуралдааны журам”, “Өмч хамгаалах зөвлөлийн ажиллах журам”, “Архив, албан хэрэг хөтлөлтийн журам”, “Орон нутаг дахь газрын ажиллах журам”-ыг байгууллагын даргын тушаалаар тус тус шинэчлэн баталсан.

Мөн Засгийн газрын 2021 оны 192 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын виз олгох журам”-д заасны дагуу Хил орчмын бүлэг жуулчин /К3/-д олгох визийн хавсралтын загварыг байгууллагын даргын 2021 оны А/150 дугаар тушаалаар баталсан.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан захиргааны хэм хэмжээний актуудад холбогдох өөрчлөлтийг тусгах, шинэчлэн батлуулах үүрэг бүхий “Ажлын хэсэг”-ийг байгууллагын даргын 8 дугаар сарын 12-ны өдрийн А/147 дугаар тушаалаар байгуулж, “Гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлэх, гарахыг түдгэлзүүлэхийг хүчингүй болгох тухай шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх журам”-д оруулах нэмэлт, өөрчлөлтийг 10 дугаар сарын 25-ны өдрийн А/184 дүгээр, “Гадаадын иргэн, харьяатын газрын статистик мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх, ашиглах журам”-ыг 10 дугаар сарын 14-ний өдрийн А/173 дугаар, “Гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн ажиллах заавар”-ыг 10 дугаар сарын 25-ны өдрийн А/185 дугаар, “Мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам”-ыг 11 дүгээр сарын 3-ны өдрийн А/191 дүгээр тушаалаар тус тус шинэчлэн баталж, нэмэлт, өөрчлөлт оруулав.

2.2.2. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА:

Хууль зүй, дотоод хэргийн Дэд сайд Б.Солонгоо 11 дүгээр сарын 19-ний өдөр байгууллагын үйл ажиллагаатай танилцсан уулзалтаар байгууллагын цахим шилжилтийг онцлон сайшаалаа.



2021 онд байгууллагын удирдлага, холбогдох албан тушаалтнууд гадаад улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд, Элчин зөвлөх, Консул, Нарийн бичгийн дарга, Атташе зэрэг дипломат албаны хүмүүс болон Олон улсын байгууллагын Монгол Улс дахь төлөөлөгчийн газрын албаны бусад хүмүүстэй 16 удаагийн уулзалтыг зохион байгуулж, хоёр улсын ижил чиг үүргийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, шинэчлэн батлагдсан Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар танилцуулах болон бусад асуудлаар харилцан санал солилцсон байна.



Мөн хамтын ажиллагааны хүрээнд холбогдох яамд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага, төлөөллийг оролцуулсан нийт 4 удаагийн уулзалтаар хил орчмын аялал жуулчлал, гадаадын хөрөнгө оруулалт татах таатай орчин бүрдүүлэх, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудын дундын мэдээллийн санг бүрдүүлэх зэрэг асуудлыг хэлэлцлээ.

Гадаад харилцааны яам, Үндэсний хөгжлийн газар, Аялал жуулчлалын холбоотой хамтран аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд шинэчлэн батлагдсан Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, холбогдох журмыг танилцуулах сургалт, зөвлөгөөнийг 8 дугаар сарын 6-ны өдөр, НҮБ-ын Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллагатай хамтын ажиллагааны хүрээнд байгуулж буй “Хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны үзэл баримтлал”-ын баримт бичгийг батлах ёслол, хүндэтгэлийн арга хэмжээг мөн сарын 16-ны өдрүүдэд тус тус зохион байгууллаа.

Монголын аялал жуулчлалын холбооноос зохион байгуулсан “ITM 2021 Аялал, жуулчлалын үзэсгэлэн яармаг” арга хэмжээнд байгууллагын үйл ажиллагааны чиглэл, үйлчилгээг 10 дугаар сарын 28-аас 30-ны өдрүүдэд сурталчлан оролцсон.

2.3. ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

2.3.1. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ:

Улсын онцгой комиссын даргын 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 04 дүгээр тушаалаар батлагдсан “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж”-ийн дагуу байгууллагын даргын 2020 оны А/262 дугаар тушаалаар Дэд даргаар ахлуулсан “Гамшгаас хамгаалах шуурхай штаб” байгуулж, 2021 оны “Гамшгаас хамгаалах шуурхай штабын бүрэлдэхүүн, бүлэг байгуулах тухай” А/53, А/92 дугаар тушаалаар “Гамшгаас хамгаалах шуурхай штаб”-ыг тус тус шинэчлэн тодотголоо.

Мөн Монгол улсын Шадар сайдын 2018 оны “Загвар батлах тухай” 120 дугаар тушаалын дагуу байгууллагын “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г шинэчлэн боловсруулж, байгууллагын даргын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн А/93 дугаар тушаалаар батлан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.



Тайлант хугацаанд Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос баталсан тогтоол, шийдвэрийг мөрдлөг болгон, холбогдох үүрэг чиглэлийг хэрэгжүүлж, бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын үед нийт албан хаагчдын тодорхой хувийг ажлын байранд, бусад албан хаагчдыг цахимаар ажиллуулах зохион байгуулалтыг тухай бүр хийж, тушаал шийдвэрээр баталгаажуулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа.

Байгууллагын даргын 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн А/39 дүгээр тушаалаар “Гадаадын иргэн, харьяатын газрын Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, байгууллагын үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ыг, түүний хавсралтаар “Гадаадын иргэн, харьяатын газрын Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед ажиллах үйл ажиллагааны горим”-ыг, 2021 оны А/53 дугаар тушаалаар “Гамшгаас хамгаалах шуурхай штаб, бүлэг, түүний ажил үүргийн хуваарь, түргэн цугларах схем”, “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын сэжигтэй тохиолдол илэрсэн үед ажиллах ерөнхий зааварчилгаа”-г, түүний хавсралтаар “Гамшгаас хамгаалах шуурхай штаб, бүлэг байгуулах тухай” тус тус баталсан.

Гадаадын иргэн, харьяатын газрын Гамшгаас хамгаалах шуурхай штабын даргын баталсан 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 02-03/03 дугаар удирдамж, төлөвлөгөөний дагуу 3 дугаар сарын 23-ны өдөр байгууллагын төв байранд Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын сэжигтэй тохиолдол илэрсэн үед томилгоот бүлгүүдийн хэрэгжүүлэх чиг үүргийг тодотгож, бэлэн байдлыг хангах, албан хаагчдын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор коронавируст цар тахлын халдварын сэжигтэй тохиолдол илэрсэн үед хариуцлагатай жижүүр, эмч болон халдвар хамгааллын хувцас хэрэглэлтэй ажиллах бүлэг, хэв журам сахиулах бүлгийн ажиллах дадлага сургуулилалтыг зохион байгуулав.

Улсын онцгой комиссын 4 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах хүрээнд Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх “Маскаа зүүцгээе, гараа угаая” 2 дугаар аяныг байгууллагын хэмжээнд зохион байгуулж, хэрэгжилтийн тайланг 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01/1934 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.



2021 онд төв болон орон нутаг дахь нэгжийн нийт 159 албан хаагч дархлаажуулалтын нэмэлт тунд хамрагдсан ба 11 дүгээр сарын 13-ны өдөр Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн 10 дугаар төвд байгууллагын төвийн 45 албан хаагчийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулж, 39 албан хаагчид Коронавируст халдвар /КОВИД-19/-ын дараах сэргээн засах эмчилгээ болон эмчийн дүгнэлтэд тулгуурласан өдрийн эмчилгээг эхлүүллээ.

Мөн нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, дархлаажуулалтыг дэмжих зорилгоор 10 дугаар сарын 28-ны өдөр байгууллагын хэмжээнд гар бөмбөг, ширээний теннис, дартсын тэмцээн зохион байгуулж нийт 6 баг тамирчид оролцсон.

2.4. АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ, ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

2.4.1. АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ:



Засгийн газрын 2020 оны 264 дүгээр тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ыг үндэслэн “Байгууллагын архивд нэвтрэх, баримт бичиг ашиглуулах журам”-ыг байгууллагын даргын А/166 дугаар тушаалаар батлан, мөрдөж байна.

Архивын баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлэн, 2013-2017 оны байнга хадгалах 358 хадгаламжийн нэгжийг е-архив программд холбож, байгууллагын архивд 2001-2017 оны нийт 565 хадгаламжийн нэгжийн 6800 файл, 114235 хуудас баримт дахь 96749 хүнийг овог нэрээр бүртгэж, цахим мэдээллийн санг баяжуулсан.

Тайлант хугацаанд байгууллагын даргаас А тушаал 215, Б тушаал 307 буюу нийт 522 тушаал баталсныг цахим хэлбэрт шилжүүлж, архив албан хэрэг хөтлөлтийн программд бүртгэн, хариуцсан албан хаагчдаар үүргийн биелэлтийг хангуулан ажиллаж байна. Харин боомт, орон нутаг дахь нэгжийн дарга нараас нь А тушаал 103, Б тушаал 116 буюу нийт 219 тушаал баталсныг бүртгэн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг тооцон ажиллажээ.

2.4.2. ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ:

2021 онд аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, албан хаагчаас нийт 420 өргөдөл, гомдол ирүүлснийг хүлээн авч, 405 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэн, 15 өргөдөл шийдвэрлэлтийн шатанд хянагдаж байна. Хуулийн хугацааг сунгаж шийдвэрлэсэн 2 өргөдөл, хугацаа хэтрүүлсэн 1 өргөдөл байна.



2.5. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

2.5.1. ПРОГРАММ ХАНГАМЖ:

“Гадаадын иргэнд бүртгэлийн дугаар олгох цахим систем хөгжүүлэх” 01/07-05 дугаартай гэрээний дагуу Гадаадын иргэнд бүртгэлийн дугаар олгох систем /RNSF/-ийг 6 дугаар сарын 1-ний өдрөөс ашиглалтад оруулсан. Тайлант хугацаанд Монгол улсад байсан болон одоо байгаа нийт 111,716 гадаадын иргэнд регистрийн дугаар олгов.

Гадаадын иргэн, харьяатын газрын “Гадаадын иргэнд бүртгэлийн дугаар олгох” /RNSF/ программ болон Хил хамгаалах ерөнхий газрын “Гадаадын иргэний био мэдээллийн бүртгэлийн систем”-ийн хооронд мэдээлэл харилцан солилцох ажил хийгдэж байна.

“Гадаад иргэнийг бүртгэх бүртгэлийн аппликейшн хөгжүүлэх” 01/07-06 дугаартай гэрээний дагуу Гадаадын иргэнийг 48 цагийн дотор гар утаснаас бүртгэх бүртгэлийн аппликейшнийг хөгжүүлж, программ хангамжийн эхний хувилбарыг 6 дугаар сарын 14-ний өдөр play store-т, 9 дүгээр сарын 30-ны өдөр APP.store-т нэвтрүүлсэн. Программаар дамжуулан тайлант хугацаанд 291 гадаадын иргэн бүртгүүлээ.

Eimmigration.mn цахим хуудсаар дамжуулан нийт 2 төрлийн тодорхойлолтыг цахимаар олгож байна. Үүнд:

- Оршин суух зөвшөөрлийн талаарх тодорхойлолт;
- Цагаач, гэр бүлийн болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэний тодорхойлолт.

Иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх зорилгоор 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн цахим төлбөрийн Гэрэгэ киоскийг үйлчилгээндээ нэвтрүүллээ. Гэрэгэ киоскоор дамжуулан байгууллагын үйлчилгээний төлбөр, тэмдэгтийн хураамж, торгууль зэрэг 66 төрлийн төлбөр төлөх боломжтой болсон. Мөн 10 дугаар сард QPAY төлбөрийн боломжийг төв байрны үйлчилгээний зааланд холбож, байршуулав.

Визийн мэдээллийн нэгдсэн сангийн хөгжүүлэгч шалгаруулах тендерт шалгарсан Интерактив ХХК 2021 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөс системийн хөгжүүлэлтийг эхлэн, 10 дугаар сарын 1-ний өдөр цахим визийн eVisa.mn сайтыг үйл ажиллагаанд нэвтрүүлж, тайлант хугацаанд нийт 94 иргэнд үйлчилгээ үзүүлжээ.

Байгууллагын цахим хуудсыг шинэчлэн, НҮБ-ын 5 хэл дээр хөгжүүлэлтийг хийлээ. 12 дугаар сарын 1-ний өдрөөс eimmigration.mn системээр дамжуулан бүх төрлийн оршин суух зөвшөөрлийн материал хүлээн авах хүсэлтийг цахимаар хүлээн авч, хариуг хүргүүлэн ажиллаж байна. Энэ хугацаанд нийт 288 хүсэлтээр 497 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.

12 дугаар сарын 15-ны өдрөөс e-mongolia.mn цахим хуудас дахь “Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөн”-ний хэсэгт байгууллагын нийт 8 үйлчилгээг нэвтрүүлж, иргэдэд шууд үйлчилгээ үзүүлж эхлээд байна.



2.6. САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХАНГАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР:

2.6.1. ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ:

2021 онд өссөн дүнгээр 6,419.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 5,669.9 сая төгрөгийг зориулалтын дагуу дагуу өр, авлагагүй, хэмнэлттэйгээр, зохих журамд нийцүүлэн анхан шатны баримтыг үндэслэн зарцуулсан.

Төсвийн шууд захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн Үндэсний аудитын газрын шалгалтад “Зөрчилгүй” дүгнэлт авч, тайлан, дүгнэлтийг 2021 оны 01/440 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын зөвлөмжийн биелэлтийг 9 дүгээр сарын 16-ны өдрийн 01/1247 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлэв.

Энэ онд давхардсан тоогоор 338 албан хаагчдад 3,745.1 сая төгрөгийн цалинг цалингийн программ болон төрийн албаны цалингийн нэгдсэн системд тооцож олгон, мэдээллийг сар бүр албан хаагчдын и-мэйл хаягаар илгээлээ.

Шилэн дансны тухай хуулийн дагуу shilendans.gov.mn цахим хуудаст тухай бүрийн 474, сар бүрийн 237, улирал бүрийн 21, хагас жилийн 28, жилийн эцсийн 28 мэдээ буюу нийт 788

**2.6.2. ОРЛОГО ТӨВЛӨРҮҮЛЭЛТ:**

2021 оны 12 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр 1,775.0 сая төгрөгийн улсын тэмдэгтийн хураамж, 214.0 сая төгрөгийн хүү, торгуулийн орлого төвлөрүүлсэн.

2021 оны 12 дугаар сарын байдлаар 703.6 сая төгрөг, 2,244 ам.долларын улсын тэмдэгтийн хураамж, 13.3 сая төгрөгийн торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, хяналтын улсын байцаагчдын шийтгэлийн хуудасны тайланг тулган баталгаажуулав.

Орон нутгийн татварын дансанд 1,736.0 сая төгрөгийн тэмдэгтийн хураамж, 215.1 сая төгрөгийн хүү, торгуулийн орлогыг тус тус төвлөрүүлсэн байна.

2.6.3. ХУДАЛДАН АВАЛТ:

Байгууллагын 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 621.8 сая төгрөгийн 5 нээлттэй тендер шалгаруулалт тусгагдсанаас 4 нээлттэй тендерийг зарлаж, үнэлгээний хорооноос ирүүлсэн зөв лөмжийн дагуу тендерт шалгарсан 6 аж ахуйн нэгжтэй 581.4 сая төгрөгийн 8 гэрээ байгуулж, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн гүйцэтгэлээр 533.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгов.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/249 дугаар тушаалаар Худалдан авах ажиллагааны 2021 оны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулж, 252.1 сая төгрөгийн урсгал засварын ажлыг нэмж тусгасныг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг баримтлан 5 аж ахуй нэгжтэй 156.5 сая төгрөгийн нийт 9 гэрээ байгуулж, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн 156.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн “2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-ний саналыг боловсруулан 01/1608 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/250 дугаар тушаалаар “2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-г батлуулан, цахим системд байршуулсан.

2021 оны худалдан авах ажиллагааны явцын тайланг сар бүр, жилийн эцсийн тайланг 2021 оны 01/1744 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлж, www.shilendans.gov.mn, www.etender.gov.mn цахим хуудаст холбогдох хугацаанд нь байршуулан ажиллаж байна.

Үндэсний статистикийн хорооноос “Аж ахуй нэгжийн 2021 оны ээлжит тооллого”-ыг улс орон даяар зохион байгуулсантай холбогдуулан төв болон орон нутаг дахь 8 нэгжийн мэдээллийг toolgo.1212.mn цахим хуудаст байршуулж, тооллогод бүрэн хамрагдлаа.

“Техникийн комиссын бүрэлдэхүүн, ажиллах журам”, “Өмч хамгаалах зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам”-ыг шинэчлэн боловсруулж, байгууллагын даргын 2021 оны А/107, А/108 дугаар тушаалаар тус тус батлав.

2021 онд байгууллагын барилга, байгууламж, цэвэр, бохир ус, холбоо, цахилгаан, дулааны шугам сүлжээний хэвийн ажиллагааг хангаж, “А”, байрны 1, 2, 3 дугаар давхрын коридор, 3 өрөө, “Б” байрны 1, 2 дугаар давхрын шат, 6 өрөөг засварлаж, “А” байрны 1,2 дугаар давхар дахь ариун цэврийн өрөөг зураг төслийн дагуу иж бүрэн шинэчилсэн.

2.7. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, АУДИТЫН ЧИГЛЭЛЭЭР:**2.7.1. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ:**

Байгууллагын 2001-2020 оны үйл ажиллагааны статистик эмхэтгэлийг нэгтгэн гаргалаа. Байгууллагын 2020 оны 12 дугаар сар болон 2019, 2020 оны харьцуулсан мэдээ, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын 2020 оны 4 дүгээр улирлын танилцуулах тойм мэдээ, 2021 оны 01 дүгээр сараас 12 дугаар сарын мэдээ, нийт 15 мэдээг 13 удаагийн албан бичгээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд, байгууллагын 2020 оны 12 дугаар сар болон 2019, 2020 оны харьцуулсан мэдээ, 2021 оны 01 дүгээр сараас 12 дугаар сарын мэдээ, нийт 14 мэдээг 12 удаагийн албан бичгээр Ерөнхий сайдын Ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлэн ажиллав.

Мөн байгууллагын үндсэн үйл ажиллагааны мэдээг 2020 оны 12 дугаар сараас 2021 оны 12 дугаар сарын 11-ний өдрийг хүртэл Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт нийт 248 удаа хүргүүлсэн.

2020 оны байдлаар хоёрдмол харьяалал үүсгэсэн иргэд болон Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэдийн мэдээ, Монгол Улсын харьяат болсон, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон, харьяатаас гарсан иргэдийн мэдээг 2021 оны н/01 дугаар албан бичгээр Үндэсний статистикийн хороонд, гадаадын иргэдийн судалгааг 01/1217 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлжээ.

“Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай” конвенцийн хэрэгжилтийг хангахтай холбогдуулан Монгол Улсын Засгийн газарт авах арга хэмжээ, анхаарах асуудлын талаар өгөгдсөн зөвлөмжийн хүрээнд байгууллагаас 2019-2021 онд хэрэгжүүлсэн арга хэмжээ буюу НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газрын орогнол хүсэгчийн гэрчилгээтэй иргэдийн бүртгэлийг 2021 оны 11 дүгээр сарын байдлаар гаргаж, 01/1514 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

2021 онд нийт 33 удаагийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг бэлтгэж, холбогдох байгууллагад тухай бүр танилцуулж ажиллалаа.

Байгууллагын дотогшоо чиглэсэн үйл ажиллагаа болох Хууль зүй, дотоод хэргийн сайдын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын 2021 оны хагас жилийн биелэлт, байгууллагын даргын 2020 онд баталсан тушаалын хэрэгжилт, албан даалгаврын 2020 оны биелэлт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2020 оны хэрэгжилт, нэгжийн дарга нарын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, иргэн, аж ахуйн нэгжээс 2020 онд байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлын бүртгэл хөтлөлт, шийдвэрлэлт, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн зөрчлийн 2020 оны мэдээ, байгууллагын 2021 оны 1, 4 дүгээр сар, 3 дугаар улирал, эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгсөн.

Байгууллагын ил тод байдлын үнэлгээ 2020 онд 100 хувь, шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ 98,56 хувиар үнэлэгдсэнийг 2019 оны үнэлгээтэй харьцуулахад байгууллагын ил тод байдлын үнэлгээ өсөлт бууралтгүй, шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ 0,66 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

“Хөгжлийн санаачилга, бодлого судлалын төв” төрийн бус байгууллагаар хэрэглэгчийн үнэлгээ болон албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааны ажлыг 11 дүгээр сарын 15-ны өдрөөс гэрээлэн гүйцэтгүүлж, тайланг хүлээн авлаа.

2.7.2. АУДИТ, НИЙЦЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор төв болон орон нутаг дахь нэгжүүдийн shilendans.gov.mn цахим хуудаст байршуулсан мэдээнд 2020 оны 4 дүгээр улирал, 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар 2 удаагийн хяналт шалгалтыг хийж, хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн эхний хагас жилийн тайланг Хууль зүй, дотоод хэргийн яаманд, мөн хуулийн 2, 3 дугаар улирлын хэрэгжилтэд дотоод аудит хийсэн тухай зөвлөмжийг 2021 оны 01/1606 дугаар албан бичгээр Санхүүгийн хэлтэс, орон нутаг дахь нэгжүүдэд холбогдох хугацаанд нь хүргүүлэв.

Санхүүгийн болон үйл ажиллагааны чиглэлээр 4, нийцлийн чиглэлээр 5, нийт 9 удаагийн төлөвлөгөөт дотоод аудитын шалгалтыг гүйцэтгэн, материаллаг бус 18 зөрчил, материаллаг 1 зөрчлийг тус тус илрүүлж, давхардсан тоогоор 3 зөвлөмж гарган, ажлын үр дүнг тухай бүр тооцож ажилласан.

“Гадаадын иргэн, харьяатын газрын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд дотоод аудитын шалгалт зохион байгуулах тухай” байгууллагын даргын 2021 оны 01-09/21 дүгээр, “Баруун бүс дэх газарт дотоод хяналт шалгалт, аудит хийх тухай” 01-09/04 дүгээр, “Хойд бүс дэх газарт дотоод хяналт шалгалт, аудит хийх тухай” 01-09/05 дугаар, “Агаарын замын боомт хариуцсан газрын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт, аудит хийх тухай” 01-09/07 дугаар удирдамжаар тус тус холбогдох үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт, аудит хийж, тайлан, зөвлөмжийг гаргалаа.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2013 оны А/248 дугаар тушаалаар баталсан “Эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу байгууллагын 2021 оны эрсдэлийн үнэлгээг тодорхойлж, тайланг 12 дугаар сарын 10-ны өдрийн 01/1747 дугаар албан бичгээр, Үндэсний

аудитын газрын 2020 оны зөвлөмжийн биелэлтийг Хууль, зүй дотоод хэргийн яаманд 12 дугаар сарын 10-ны өдрийн 01/1746 дугаар албан бичгээр тус тус хүргүүлэв.

Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу байгууллагад хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хууль зүй, дотоод хэргийн сайдын нийтээр дагаж мөрдөхөөр баталсан захиргааны хэм хэмжээний 4 акт, байгууллагын даргын баталсан хүчин төгөлдөр үйлчилж байгаа нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний 4 актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн 2021 оны 01/979, 01/1037 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн.

2.8. ХИЛИЙН БООМТ, ОРОН НУТГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар баригдаж байгаа Замын-Үүд боомтын цогцолборын барилгын зорчигчийн хэсгийн ажил 52,0 хувь, ачаа тээврийн хэсгийн ажил 37,0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Өмнөговь аймгийн Хүрмэн сумын нутагт шинээр байгуулах хилийн Цагаандэл-Уул боомтын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өлзий боомтоос шаардлагатай тоног төхөөрөмж, зөөврийн орон сууц, бараа материал татан авах зорилгоор хилийн түр гарцыг 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс 10 дугаар сарын 25-ны өдрийн хооронд нээж, Гаалийн ерөнхий газрын 5, Хилийн 0131 дүгээр ангийн 8, Өмнөговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 8, Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газрын 4, Өмнөговь аймгийн Тагнуулын газрын 1, Гадаадын иргэн, харьяатын газрын Өмнөд бүс дэх газрын 1 нийт 27 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр 10 дугаар сарын 22-ноос 23-ны өдрүүдэд шаардлагатай тоног төхөөрөмж, зөөврийн орон сууц, бараа материалыг татан авч ажилласан.

Монгол Улсын Засгийн газраас Боршоо авто замын боомтын барилга, дэд бүтцийн шинэчлэлийг Азийн хөгжлийн банкны 9,4 сая ам доллар буюу 26 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 2020 оны 6 дугаар сараас эхлэн 2 жилийн хугацаанд бүрэн ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Боомтын шинэчлэл төслөөр боомтын цогцолбор барилга (3200 м² талбайтай) болон орчин үеийн систем бүхий рентген авто машин шалгах төхөөрөмж, цахилгаан авто пүү, хяналтын ухаалаг (нийт 5) гарц, машин ариутгах байр, инженерийн дэд бүтэц бүхий 30 айлын орон сууц зэрэг 20 гаруй барилга байгууламж баригдахаар төлөвлөсөн.

Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын захиалгаар Булган боомтод тус газрын албан хаагчдын амьдрах 76,39 м² талбайтай 4 өрөө бүхий 50 сая төгрөгийн өртөгтэй тоосгон барилгын ажлыг “Эрдэнийн шим” ХХК-аар гүйцэтгүүлж, барилга хүлээн авах комисст хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.

Баян-Өлгий аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн “Баян-Өлгий аймгийн 2021 оны төсөв батлах тухай” 16 дугаар тогтоолоор Гадаадын иргэн, харьяатын газрын Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн “Цагааннуур” хилийн боомт дахь алба хаагчдын амьдрах байр бариулах зориулалтаар 25,000,000 (Хорин таван сая) төгрөгийн хөрөнгө шийдвэрлүүлж, 500 м² эзэмшлийн газар, 110 м² байшинг худалдан авсан.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Сэлэнгэ аймагт байрлах Сүхбаатар хилийн боомтод баригдаж байгаа хилийн хяналтын байгууллагуудын нэг цэгийн үйлчилгээний цогцолборын 6 давхар барилгын ажлын явцын гүйцэтгэл 95,0 хувьтай, 2022 оны 6 дугаар сард ашиглалтад оруулахаар төлөвлөжээ. Мөн Сангийн яам, Гаалийн ерөнхий газар нь Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр “Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл”-ийг хэрэгжүүлэн төслийн хүрээнд Алтанбулаг хилийн боомтын барилга байгууламжийн өргөтгөл, шинэчлэл, барилга угсралтын ажил хийгдэж байна.

Хилийн боомтод ажиллаж буй албан хаагчдын ажиллах, амьдрах нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд Зүүн бүс дэх газар нь Эрээнцав, Ульхан боомт дахь албан хаагчийн амьдрах байранд урсгал засвар хийж, Хавирга, Баянхошуу, Бичигт, Эрээнцав, Ульхан боомтын албан өрөөнд хяналтын камер тус тус суурилуулсан.